НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 19 өдөр Дугаар А/02 Улаанбаатар хот

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийх аудитын багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн "Баганууур дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 09 дүгээр тогтоол, дүүргийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн "Чанарын баг байгуулах тухай" А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газарт хэрэгжүүлж буй олон улсын чанарын менежментийн тогтолцооны шаардлага ISO 9001:2015, ISO 18091:2020 стандартын хэрэгжилтэд дотоод аудит хийх аудитын багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Зөвлөхөөс өгсөн чиглэлийн дагуу холбогдох ажлуудыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэхийг Аудитын багт үүрэг болгосугай.

3.Дотоод аудитыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, аудитын тайланг танилцуулахыг Ахлах аудитор (Н.Оюунцэцэг)-т даалгасугай.

ДАРГА П.БАТТҮШИГ

D:\2023\Tushaal\TUSHAAL.docx

1202030028

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын
Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын
19. -ны өдрийн 01/02 дугаар тушаалын хавсралт

Дотоод аудит хийх аудитын багийн бүрэлдэхүүн

Д/д	Хариуцсан ажил	Нэрс	Албан тушаал
1	2	3	4
1	Ахлах аудитор	Н.Оюунцэцэг	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
2	Аудитор	Б.Лхамсүрэн	1 дүгээр хорооны Засаг дарга
3		О.Баттулга	Цэргийн штабын Төлөвлөлт, сургалтын офицер
4		Э.Уянга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хяналт шинжилгээ үнэлгээ, захиргааны зохион байгуулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн
5		Б.Цогзолмаа	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хороо, иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлт хариуцсан мэргэжилтэн